

ГҮТГЭХ ҮЙЛДЛИЙН ТАЛААРХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН  
ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Б.Баярмаа\*

\*МУИС-ийн Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн багш, магистр (МА)

**Түлхүүр үгс:** Гүтгэх үйлдэл, хүний нэр төр, алдар хүнд, эрүүгийн хэрэг, иргэний хэрэг, хэвлэлийн эрх чөлөө.

**Н**эрт сэтгэл судлаач Зигмунд Фройд “Чулуу шидэхийн оронд хараал хэлсэн анхны хүн соёл иргэншлийг үүсгэгч юм” гэсэн нь хүн хоорондын харилцааны мөн чанарыг харуулдаг. Хүн төрөлхтний харилцаа зөрчлөөр дүүрэн бөгөөд түүнийг зохицуулна гэдэг мөн нэн төвөгтэй асуудал билээ. Монгол Улс хэвлэлийн эрх чөлөөний индексээр 2022 онд 22 байр ухарч, 180 орноос 90 дугаарт бичигдэх болсон (Хил хязгааргүй сэтгүүлчид, 2022). Корона вирусний цар тахлын үеэр Засгийн газраас хэрэгжүүлсэн арга хэмжээ болон улс төрийн нөхцөл байдалтай холбоотойгоор гүтгэх, доромжлох үйлдлийн эрх зүйн зохицуулалтыг сэтгүүл зүй болон хууль зүйн салбарт идэвхтэйгээр нарийвчлан судалж байна. Энэ нь Засгийн газраас 2022-2024 он хүртэл хэрэгжүүлэх төлөвлөгөөнд мэдээлэл харилцаа, холбооны салбарт эрх зүйн шинэчлэлт хийхээр төлөвлөсөнтэй мөн холбоотой байна. Засгийн газар болон УИХ-ын захиалгаар 2017 онд “Монгол Улс дахь халдашгүй, чөлөөтэй байх эрх, түүний хэрэгжилт”, “Цахим болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр бусдын нэр

төрийг гутаах, гүтгэх, доромжлох, хуурамч мэдээлэл тараах үйлдэлд хүлээлгэх хариуцлага, бусад орнуудын туршлага” 2022 онд “Монгол Улс дахь хэвлэл мэдээллийн өнөөгийн байдал ба түүнийг олон улсын сайн жишигт нийцүүлэх нь” зэрэг өргөн хүрээ хамарсан цөөнгүй судалгаа хийжээ. Мөн “Глоб интернэшнл”, “Хэвлэл мэдээллийн зөвлөл”, “Нээлттэй нийгэм форум” зэрэг байгууллагууд гүтгэх үйлдэлтэй холбоотой сэтгүүл зүйн салбарын эрх зүйн зохицуулалтын талаар идэвхтэй судалж, саналаа дэвшүүлж буй. Үр дүнд нь Монголын хууль зүй болон сэтгүүл зүйн салбарт гүтгэх үйлдлийн талаарх нэгдсэн ойлголт тогтож, олон талын байр суурь бий болж, олон улсын зохицуулалтын талаарх мэдээллийн сан бүрдэж байна. Төрийн байгууллагуудын зүгээс гүтгэх үйлдлийг Эрүүгийн хуулиар хатуу зохицуулдаг орнуудыг түлхүү судалж байгаа бол иргэний нийгмийн байгууллагууд хэвлэлийн эрх чөлөөг дэмжсэн зөөлөн зохицуулалттай орнуудын эрх зүйн орчныг судлах түгээмэл хандлага ажиглагдлаа. Энэхүү ажил нь гүтгэх үйлдлийг зохицуулж буй олон улсын туршлагыг танилцуулах, Монголд үйлчилж байгаа гүтгэх үйлдэлтэй холбоотой гол эрх зүйн зохицуулалтуудын суурь нөхцөлийг тайлбарлаж, задлан шинжлэх зорилготой юм.

Олон улсад гүтгэх үйлдлийг хэрхэн зохицуулах талаар хоёр үндсэн хандлага байна. Эхнийх нь, гүтгэх үйлдэл нь хүний нэр төр, алдар хүндэд халдсан ноцтой үйлдэл бөгөөд үүнийг таслан зогсоохын тулд заавал хатуу шийтгэл оногдуулах нь зүйтэй гэж үздэг. Хэн нэгнийг хийгээгүй үйлдлийнх нь төлөө гүтгэсний хор уршиг их. Тиймд шийтгэл нь хатуу байж гэмээнэ бусдыг гүтгэх явдал буурна гэсэн үзэл баримтлалаар эрх зүйн зохицуулалтдаа хандаж байна. Эрүүгийн эрх зүй нь гэмт хэргийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх гол зорилготой. 2022 оны байдлаар дэлхийн 160 улсад гүтгэлгийг гэмт хэрэгт тооцон ял шийтгэл эдлүүлсэн хэвээр байгаа юм (Иргэний оролцоо төсөл, 2022). Азарбейжан, Польш, Испани, Герман, Австри, Япон, Финланд, БНХАУ зэрэг орнууд Эрүүгийн хуулиар зохицуулах заалттай. Гэхдээ эдгээр орнуудын ийм төрлийн гэмт хэрэгт тавьж буй гэмт хэргийн бүрэлдэхүүн, нөхцөл нь тухайн орны улс төрийн болон эрх зүйн тогтолцооноос шалтгаалан нэлээд ялгаатай. Хэвлэлийн эрх чөлөөний үзүүлэлтээр 175-д жагсаж буй БНХАУ-ын эрх зүйн зохицуулалтыг авч үзье.

БНХАУ-ын хувьд гүтгэх, доромжлохтой холбоотой үйлдлийг Эрүүгийн хуульд нарийвчлан тусгаснаас гадна 1987 онд баталсан Хятадын иргэний нэр төр гутаах, гүтгэхтэй холбоотой хуулийн /Chinese Civil Defamation Law, 1987/ 101-р зүйлд “Иргэний нэр төрийг хуулиар хамгаалах ба нэр төр гутаах, гүтгэх, доромжилж хор хохирол учруулахыг хуулиар хориглоно” гэж заасан. БНХАУ-ыг Эрүүгийн хуульд зааснаар олон нийтийн өмнө бусдын нэр төрийг гутаан доромжилсон, худал мэдээлэл тараасан этгээдийг богино хугацаагаар хорих, эсхүл 500 юаниар торгох хариуцлага хүлээлгэнэ. Баримт

бичгийг хуурамчаар үйлдсэн этгээдийг хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял эдлүүлнэ. Нас барсан хүнийг олон нийтийн өмнө басамжлан доромжилсон этгээдийг богино хугацаагаар хорих, эсхүл 300 юанийн торгох ял ногдуулна (УИХ-ын Тамгын газар, 2017) гэх зэргээр нарийвчлан, нэлээд дэлгэрэнгүй тусгасан байна. Түүнчлэн 2013 онд Хятадын Ардын Дээд Шүүх, Ардын Дээд Прокуророос цахим мэдээллийн хэрэгслээр нэр төр гутаах, гүтгэхтэй холбоотой асуудлуудаар хамтарсан тайлбар гаргажээ. Энэ нь нийгмийн сүлжээнд худал мэдээлэл тараахтай холбоотой дэлгэрэнгүй заалттай. БНХАУ коммунист системээс шалтгаалан хэвлэлийн агуулгад нэн хатуу хязгаарлалт тавьдаг, иргэдийн үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хаадаг. Гүтгэх үйлдлийг үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөтэй эсрэгцүүлэн авч үзэж, олон нийт болон хэвлэл мэдээллийн хэрэгслийн дээрх эрхийг хянах гол зохицуулалт болгож байна.

Гүтгэх үйлдлийг эрх зүйн системд зохицуулж буй хоёр дахь хандлага нь илүү уян хатан, зөөлөн шинжтэй. Энэ хандлага нь гүтгэх үйлдлийг ерөөс хуулиар зохицуулж болохгүй гэсэн агуулгатай биш, харин гүтгэх үйлдэл нь санаа зоригийн хувьд ялгаатай гэж авч үздэг. Тодруулбал, бусдыг санаатайгаар гүтгэх нь гэмт хэрэг бол санаандгүйгээр гүтгэсэн бол эвлэрүүлэн зуучлах, гомдол гаргагчийн нэр хүндийг сэргээх, гүтгэсэн этгээдэд сануулга, зөвлөмж өгөх замаар зохицуулж байна. Ийм зөөлөн арга хэлбэр нь хэвлэлийн эрх чөлөөний үзүүлэлтээр дээгүүрт бичигддэг, хэвлэлийн өөрийн зохицуулалт сайн хөгжсөн орнуудад бий. Хэвлэлийн эрх чөлөөний үзүүлэлтээр 2022 онд хоёр байр урагшилж 44 дүгээрт бичигдэж байгаа АНУ-ын дээд

шүүхийн жишиг шийдвэрийг авч үзье. Тус улс нь Үндсэн хуулийн нэгдүгээр нэмэлт өөрчлөлтөөр хэвлэлийн эрх чөлөөг баталгаажуулан хамгаалсан. АНУ нь Англи-Саксоны эрх зүйн тогтолцоотой учраас шүүх өмнөх жишиг шийдвэрүүдийг харгалзан шийдвэр гаргадаг онцлогтой.

“Нью Йорк Таймс” сонин болон Салливаны хэрэг (1964) нь АНУ-ын Дээд шүүх Үндсэн хуулийн нэгдүгээр нэмэлт өөрчлөлтийг ашиглан үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хамгаалж, төрийн албан тушаалтны нэр төрд халдсан хэргээр шүүхэд хандах боломжийг хязгаарласан чухал шийдвэр юм. 1960 онд “The New York Times” сонинд хүний эрхийн төлөө тэмцэгч Мартин Лютер Кингийн дэмжигчдийн сурталчилгааны хуудас нийтлэгдсэн. Уг сурталчилгаанд Алабама мужийн Монтгомери хотод болсон иргэний эрхийн эсэргүүцлийн жагсаалыг дүрсэлж, Мартин Лютер Кингийг магтан сайшаасан байв. Мөн Африк гаралтай америкчуудын эрхийг зөрчсөн хэд хэдэн албан тушаалтнуудыг шүүмжилсэн. Сурталчилгаанд хэд хэдэн ноцтой алдаа байсан бөгөөд энэ нь Монтгомеригийн цагдаагийн комиссарыг гүтгэсэн гэж нэхэмжлэл гаргах үндэслэл болжээ. Алабама мужийн Дээд шүүх “АНУ-ын Үндсэн хуулийн нэгдүгээр нэмэлт өөрчлөлт гүтгэсэн нийтлэлийг ч хамгаална” гэж үзсэн. Дээд шүүхийн шүүгч Уильям Бреннаны бичсэн дүгнэлтэд “олон нийтийн асуудлаарх мэтгэлцээн, хэлэлцүүлэг нь саадгүй, нээлттэй байх ёстой гэсэн зарчмаар уг асуудлыг хянан үзэв... тухайн мэдээлэл худал байсан ч бодит шүүмжлэл өрнүүлж буй санаа зоригийг харгалзан үзэх ёстой (Cornell Law School, 2022)” гэж тайлбарласан. Тодруулбал, тухайн мэдээлэл худал, гүтгэсэн байсан ч

санаа зорилго нь олон нийтийн эрх ашигт нийцэхээр бол уг нийтлэл, нэвтрүүлгийг хамгаалах ёстой. Ингэснээр олон нийтийн дунд хэлэлцүүлэг өрнөж, ардчиллыг бэхжүүлэхэд тустай гэж үзсэн. Хамгийн чухал нь уг хэргийн жишгээр тус улсад төрийн өндөр албан тушаалтнуудыг гүтгэсэн, нэр төрд нь халдсан бол Үндсэн хуулийн нэгдүгээр нэмэлт өөрчлөлтийн дагуу үл хэрэгсдэг болсон билээ.

**М**онгол Улсын хувьд Эх газрын буюу Ром-Германы эрх зүйн тогтолцооны жишгээр хөгжиж байна. Ром-Германы эрх зүйн аймгийн гол шалгуур нь уг аймагт хамрагддаг улс орнуудын эрх зүйн үүсэл, эх сурвалж нь бичигдмэл эрх зүйн хэм хэмжээний нэгдмэл байдал мөн. Энэ аймаг нь Ром-Германы эрх зүйн алийг нь хэрэглэдэг. Тэгэхдээ Ромын эрх зүй нь Ромын хувийн эрх зүй, заншлын эрх зүйг илүүтэй хэрэглэж, түүнд суурилдаг. Эрх зүйн энэ аймагт Евроазийн эх газрын болон Латин Америкийн ихэнх орнууд хамаардаг, түүний дотор Монгол Улс ч орно (Хууль зүйн яам, 2013).

Эрх зүйн позитивист бус хандлагаар авч үзвэл, гүтгэх үйлдлийн талаарх эрх зүйн гол зохицуулалтад Монгол Улсын нэгдэн орсон зохих пактуудаас гадна Монгол Улсын Үндсэн хууль, Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Иргэний хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хууль, Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчим зэргийг багтаан ойлгож болно. Учир нь эрх зүйн позитивист бус хандлага нь эрх зүйд хууль тогтоогчийн баталсан хуулиас гадна тухайн орны зан заншил, нийгмийн хэм хэмжээ,

салбарын өөрийн зохицуулалтыг багтаан үздэг.

**И**нгээд гүтгэх үйлдлийг зохицуулж буй хамгийн их маргаантай бөгөөд гол баримт бичиг болох Эрүүгийн хуулийг авч үзье. Монгол Улсад эрүүгийн төрөлжсөн анхны хууль нь 1926 оны “Шүүх цаазын бичиг” байв. Үүнээс хойш 1929, 1934, 1942, 1961, 1986, 2002 (Нарангэрэл С, 2007) 2015 онуудад Эрүүгийн хуулийг тус тус шинэчлэн баталсан. 1961 оны Эрүүгийн хуулийн 19.А-д “БНМАУ-ын засаг төрийг бусниулан доройтуулах зорилгоор ухуулах буюу сурталчлах, мөн зорилгоор БНМАУ-ын нийгэм, төрийн байгууламжийг гутаахад чиглэсэн гүтгэлэг тараах, мөн ийм агуулгатай ном хэвлэл бэлтгэх буюу тараасан байвал таван жил хүртэл хугацаагаар хорьж шийтгэнэ” гэж тусгасан байв. 1986 оны Эрүүгийн хуулийн 117 дугаар зүйлд “Бусдын нэр төр, алдар хүндийг гутаасан илт худал гүжирдлэг тараасан бол, 2002 оны 111-р зүйлд “Хүний нэр төр, алдар хүндийг гутаах зорилгоор илт худал гүжирдлэг тараасан бол, 2015 оны 13.14 дүгээр зүйлд (2020 онд нэмж оруулсан) “Хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндэд халдсан илт худал мэдээллийг олон нийтэд тараасан бол” эрүүгийн гэмт хэрэгт тооцох тухай заалт орж, өдгөө хүчин төгөлдөр хэрэгжиж байна.

Дээрхээс үзвэл Монгол Улс гүтгэх үйлдлийг эрүүгийн гэмт хэрэгт тооцдог олон жилийн уламжлалтай. Хэдийгээр 2017 онд олон улсын байгууллагуудын зөвлөмж, сэтгүүл зүйн салбарынхны шахалт, шаардлагаар Эрүүгийн хуулиас хассан ч Зөрчлийн тухай хууль, УИХ-ын Сонгуулийн тухай хуульд оруулсан нь шүүмжлэлд өртсөн. Ингээд 2020 онд Эрүүгийн хуульд гүтгэх үйлдлийг “илт худал мэдээлэл” гэсэн

томъёоллоор оруулсан нь Монголын сэтгүүл зүйн салбарын хараат бус байдалд сөргөөр нөлөөлөхүйц байгааг судлаачид тэмдэглэсээр байна.

Өнөөдөр хүчин төгөлдөр хэрэгжиж буй Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр заалт нь хуулийн анхны төслөөсөө ялгаатай. Засгийн газраас хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор Эрүүгийн болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх, Зөрчлийн болон Зөрчил шалган шийдвэрлэх, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Эрүүгийн багц хуулийн төслийг 2019 онд УИХ-д өргөн мэдүүлсэн. Анх өргөн мэдүүлсэн төслийн “гүтгэх” гэснийг “худал мэдээлэл тараах” гэж өөрчлөн, “...хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндэд халдаж илт худал мэдээллийг нийтийн сүлжээгээр тараах, хэвлэл мэдээллийн хэрэгслээр тараах” гэж ялгамжтай авч үзсэн байсныг нэгтгэн уг гэмт хэргийг “олон нийтэд тараасан бол” хэмээн объектив талын шинжээр нь тодорхойлж, субъектив талын шинжийг бүрхэгдүүлсэн (уг гэмт хэргийн объектив, субъектив шинжийг тэнцвэргүй тодорхойлсон), худал мэдээлэл нь “гутаасан, гутаах” агуулга, шинжтэй байх эсэхийг бүрэн тодорхойлоогүй, “халдсан” гэсэн хэт ерөнхий нэр томъёог хэрэглэсэн явдал нь хууль бүтээх ажиллагааны алдаа болж хууль хэрэглээ, шүүхийн практикт сөрөг үр дагавар үүсгэж буй гол шалтгаан болсон гэж үзэх үндэстэй юм. Хууль тогтоогч хууль зүйн техникийн шаардлагатай агуулгыг бүрэн бүрдүүлэх шаардлага, дүрмийг зөрчиж, эрх зүйн хийдэл гаргажээ... Мөн уг зүйлийн тайлбар болох “Энэ гэмт хэргийн хохирогчид төрийн байгууллага хамаарахгүй. Үзэл бодлоо илэрхийлэхдээ улс төрд нөлөө бүхий этгээдийг гэмт

хэрэгт хардсан, сэрдсэн бол энэ гэмт хэргийг үйлдсэнд тооцохгүй” гэснийг хассан байна. Уг тайлбарыг хэлэлцүүлгийн явцад хассан явдал нь мөн хууль зүйн техникийг бүрэн бүрдүүлэх шаардлагыг алдагдуулан, хуулийн төсөлд анх тусгагдсан томъёолол нь хэлэлцүүлгийн явцад дэмжигдэхгүй хасагдаж батлагдсаны улмаас эрх зүйн хийдэл, давхардал үүсгэж, үг хэлэх эрх, мэдээллийн эрх чөлөөний эрх зүйн байдлыг дордуулах үндэс болсон байна гэж “Нээлттэй нийгэм форум” байгууллагын “Худал мэдээлэл тараах гэмт хэргийг хянан шийдвэрлэж буй практик” судалгаанд дүгнэсэн нь үндэстэй.

2015 оноос эхлэн эрүүгийн эрх зүйн салбарт Германы эрүүгийн эрх зүйн жишгээр шинэчлэл хийж байгаа нь гүтгэх гэмт хэргийн өнөөгийн зохицуулалтад шууд нөлөөлсөн гэж болно. Хуулийн төсөл санаачлагчид Германы эрүүгийн эрх зүйд гүтгэх үйлдлийг зохицуулах жишгийг дагахаар төсөлдөө тусгасан ч УИХ-ын чуулганаар батлагдахдаа гүтгэх үйлдлийг уян хатан зохицуулах гол нөхцөлүүд хасагдсан. Германы Эрүүгийн тухай хуулиар гүтгэх гэмт хэргийн санаа зоригийн асуудлыг нэн чухалд тооцон шийдвэрлэдэг байна. Тодруулбал, бусдын нэр хүндэд

зориудаар халдсан уу эсвэл мэргэжлийн санамсаргүй алдаа гаргасан уу гэдгийг шүүх байгууллага харгалзан үздэг. Ингэснээр сэтгүүлч мэдээлэл, баримтыг дутуу нягталсан, нягтлах нотлох боломжгүй байсан ч заавал олон нийтэд мэдээлбэл зохих сэтгүүл зүйн бүтээлд уг заалт хамаарахгүй болно. Хэрэв илт худал мэдээлэл тараах, гүтгэх үйлдэлд санаа зоригийн нөхцөл тавивал Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн дагуу мөрдөн байцаагч тухайн сэтгүүлчийг гомдол гаргагчийг зориудаар гүтгэсэн гэсэн нотолгоо олж чадахгүй бол яллаж чадахгүй гэсэн үг. Тиймд энэ заалт нь сэтгүүл зүй, үзэл бодол, ардчиллыг хөгжүүлэхэд саад болдоггүй. Харин манайд үйлчилж буй гүтгэх гэмт хэргийн талаарх заалт нь илт санаатайгаар гүтгэх, худал мэдээлэл тараах, доромжлох, сэтгүүлчийн мэргэжлийн алдаа гэсэн хоорондоо ялгаатай үйлдлүүдийг нэг томъёололд хамруулсан нь хамгийн гол доголдол юм. Мөн дээр дурдсанаар хэргийг шийдэх процесс нь алдаатай байгаа нь иргэдийн үзэл бодлоо илэрхийлэх, шүүхээр шударгаар шүүлгэх эрхэд ч мөн сөргөөр нөлөөлж байна.

Шийдвэрлэсэн байдал	2002 оны Эрүүгийн хуулийн зохицуулалт		2015 оны Эрүүгийн хуулийн зохицуулалт
	110.Доромжлох	111.Гүтгэх	13.14. Худал мэдээлэл тараах
Шийдсэн	3	10	20
Гэм буруутай гэж үзсэн	3	8	20
Хэрэгсэхгүй болгосон	3	5	-
Цагаатгасан	-	2	-
Торго ялаар шийтгэсэн	-	7	19
Баривчлах, хорихоор шийтгэсэн	-	1	-
Зорчих эрхийг хязгаарласан	-	-	1

Хүснэгт 2. Шүүхээс шийдвэрлэсэн нэр төр гутаах эрүүгийн хэргийн холбогдогчдын тоо, 2016-2021  
Эх сурвалж: “Монгол улс дахь хэвлэл мэдээллийн эрх чөлөөний өнөөгийн байдал ба түүнийг олон улсын сайн жишигт нийцүүлэх нь” судалгааны тайлан.

**Х**эдийгээр олон улсад гүтгэх гэмт хэргийг эрүүгийн хууль тогтоомжоор зохицуулах нь давамгайлж, Монголд мөн ингэж зохицуулж ирсэн уламжлал байгаа ч олон улсын байгууллагууд үүнийг эсэргүүцэж ирсэн нь улс төрчдийн хандлага, олон нийтийн мэдээллийн боловсрол, эрүүгийн эрх зүйн орчинтой холбоотой. НҮБ зэрэг олон улсын байгууллагуудын зөвлөмжөөр Гана, Украин, Шри Ланка, Босни Херцоговин, Гүрж зэрэг хөгжиж буй орнууд Эрүүгийн хуулиасаа гүтгэх үйлдэлтэй холбоотой заалтыг хассан. Энэ хэсэгт олон улсын хүний эрх, хэвлэлийн эрх чөлөөг хамгаалдаг байгууллагууд яагаад Эрүүгийн хуулиар зохицуулахыг эсэргүүцдэгийг тайлбарлана.

- *Зайлшгүй байх нөхцөлийг хангадаггүй.* Хүний үндсэн эрх болох үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хязгаарлахад заавал хангах ёстой гол нөхцөлийг Монгол Улсын Үндсэн хуульд заасан. Эдгээр гол нөхцөлөөс зургаан нь танилцуулъя. (1) Үндсэн эрхийг гагцхүү хуулиар хязгаарлах; (2) хязгаарлалт нь үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөө, эсхүл нийгмийн дэг журам гэсэн ашиг сонирхлыг хангах; (3) хязгаарлалт нь тохирсон (зайлшгүй) байх; (4) үндсэн эрхийг эдлүүлэх, (5) ялгаварлан гадуурхахгүй байх, (6) хараат бус шүүхээр хянадаг байх (О.Мөнхсайхан, 2017) зэрэг юм. Эрүүгийн хуулийн гүтгэхтэй холбоотой заалт нь дээрх шалгууруудаас “хязгаарлалт нь тохирсон байх” буюу зайлшгүй гэсэн нөхцөлийг хангадаггүй гэж үздэг. Учир нь манай улсын жишээгээр уг үйлдлийг Иргэний хуулийн 511.1 дэх заалтаар түлхүү зохицуулж ирсэн туршлага байна. 1999-2021 оны хооронд шүүхээр сэтгүүлч, хэвлэл

мэдээллийн хэрэгсэлтэй холбоотой 41 эрүүгийн хэрэг шийдвэрлэсэн бол 442 иргэний хэрэг шийдсэн нь манай улсын шүүхийн практикт иргэний эрх зүйгээр зохицуулах нь давуу байгааг харуулна.

- *Иргэний хуулиар сэтгэл санааны хохирлыг мөнгөн дүнгээр барагдуулах боломжтой.* Гүтгэх үйлдлийн үр дагавар нь тухайн хүний нэр төр, алдар хүндэд сөргөөр нөлөөлөх явдал. Тиймд нэхэмжлэгч гүтгэсэн, худал мэдээллийг тухайн хэвлэл мэдээллийн хэрэгслээр залруулах, уучлалт гуйлгах, мөнгөн төлбөр авах сонирхолтой байдаг. Эрүүгийн хуулиар торгох ял нь “дөрвөн зуун тавин нэгжээс нэг мянга гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох (Эрүүгийн хууль, 2015)” (450 мянгаас 1.3 сая төгрөг) заалттай. Харин Иргэний хуулиар нэхэмжлэгчийн хохирлыг барагдуулах мөнгөн дүнгийн хязгаарыг одоогоор тодорхойлох боломжгүй байна. Гэхдээ сэтгүүлч, хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийг нэр төр, алдар хүндэд халдсан гэж үзсэн улс төрчид 100 сая төгрөгийн жишиг тогтоосон нь өдгөө ч хэрэгжиж буй. Эдгээрээс үзвэл хохирогчийн хувьд Иргэний хуулийн 511.1-ээр зохицуулах нь ашигтай, давуу байх боломжтой юм.
- *Улс төрчид, төрийн өндөр албан тушаалтнууд олон нийтийн шүүмжийг зогсооход ашигладаг.* Гүтгэх, худал мэдээлэл тараах үйлдлийг заавал гэмт хэрэгт тооцож, Эрүүгийн хуулиар зохицуулах шаардлагагүй гэж хэвлэлийн эрх чөлөөг дэмждэг байгууллагууд үзэж буйн хамгийн гол шалтгаан нь Монгол Улсын улс төр, эрх зүйн тогтолцоо, хэвлэлийн эрх чөлөөний нөхцөл байдалтай холбоотой. Гүтгэх үйлдэлтэй холбоотой

шүүхэд нэхэмжлэл гаргагчдын гуравны нэг нь улс төрчид. Тиймд улс төрийн нөлөөгөө бэхжүүлэх, олон нийтийн шүүмжлэлийг зогсоох зорилгоор энэ заалтыг ашиглах замаар үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөнд халдаж буй нь хамгийн гол эсэргүүцэх шалтгаан болж байна. “Илт худал мэдээлэл тараах” гэсэн заалт 2020 оны нэгдүгээр сард Эрүүгийн хуульд орсон. Харин хууль зүйн сайд Х.Нямбаатар уг заалтын дагуу гомдол гаргасан эрүүгийн хэргийг 2020 оны наймдугаар сарын 20-нд Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр хэлэлцэж, шийдсэн байна. Шүүгдэгч “цахим сайт болон олон нийтийн телевизээр 14 настай хүүхдийг насанд хүрсэн хүн гэж үзнэ гэсэн утгатай мэдээлэл явж байсан. Уг мэдээллийг уншихад УИХ-ын гишүүн Х.Нямбаатарын санаачилсан хуульд тэгж тусгагдсан байна гэсэн утга бүхий мэдээлэл фейсбүүкээр яваад байхаар нь би үнэхээр тийм хууль санаачлан батлуулсан юм байх гэж бодоод өөрөө охин хүүхэдтэй учир Нямбаатар гишүүний санаачилсан тэр хуулийг нь эсэргүүцэж пост бичсэн юм (shuukh.mn, 2020)” гэх зэргээр мэдүүлээд Х.Нямбаатар сайдаас уучлалт гуйж, мэдээллээ устгаж, 450 мянган төгрөгийн торгох шийтгэл хүлээжээ. Уг хэрэгт өмнөх АНУ-ын дээд шүүхийн жишиг шийдвэр шиг худал, гүтгэсэн мэдээллийн санаа зоригийн асуудлыг огт авч хэлэлцээгүй байна. Мөн 2020 оны есдүгээр сарын 4-нд дээрхтэй адил мэдээллийг фейсбүүк хуудаастаа бичсэн иргэнийг 500 мянган төгрөгөөр шийтгэсэн шүүх хурал болсон. Эдгээр хэргүүд нь Монголд илт худал мэдээлэл, гүтгэхтэй холбоотой үйлдлийг эрүүгийн эрх зүйн процессын

алдаатай шийдвэрлэж, санаа зоригийн асуудлыг авч үзэхгүй байгаагийн илрэл юм. 2021 онд хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндэд халдсан илт худал мэдээллийг олон нийтэд тараасан гэмт хэрэгт 20 хүнийг гэм буруутай гэж шүүхээс шийдсэн бөгөөд үүнээс 19 хүнд торгох ял, 1 хүнд зорчих эрхийг хязгаарлах ял ногдуулсан байна (Иргэний оролцоо төсөл, 2022).

**Х**эвлэлийн эрх чөлөөний гол үндсэн суурь нөхцөл нь олон нийтийн үзэл бодлоо илэрхийлэх эрх, эрх чөлөө байдаг билээ. Тиймд олон нийт ардчилсан нийгэмд улс төрчдийг шүүмжлэх (олон нийт интернэт орчин дахь бүх мэдээллийн үнэн бодитойг шалгах боломжгүй)-ийг хуулийн заалтаар далайлган таслан зогсоох нь хэвлэлийн эрх чөлөө, ардчилсан нийгэмд ихээхэн хор уршигтай.

- *Эрүүгийн байцаан шийтгэх процесс нь хүний эрхийг зөрчдөг.* НҮБ-ын дур зоргоор саатуулах асуудал хариуцсан Ажлын хэсгийн судалгаагаар 2020 онд баривчлах ажиллагааны 99.3 хувь нь шүүхийн шийдвэргүйгээр хийгдсэн байна. Харин 2021 онд энэ тоо 98.3 хувь болжээ. Ялангуяа, Тагнуулын ерөнхий газар, Авилгатай тэмцэх газар зэрэг мэргэжлийн байгууллагууд шүүхийн зөвшөөрөлгүйгээр баривчлах нь газар авч байгаа (lkon.mn, 2022) нь сэтгүүлчдийн аюулгүй байдалд эрсдэл болж байна. 2022 оны зургадугаар сард Gerelnews.mn сайтын сэтгүүлч Г.Гэрэлмааг сурвалжилга хийж байхад нь цагдаа нар шүүхийн шийдвэргүйгээр баривчлан, камер, микрофон, гар утсыг нь хурааж, гар утас дээрх мэдээллийг нь устгаж, биед нь халдсан хэрэг гарсан.

Цагдаагийн алба хаагчийн ийм үйлдэлтэй холбоотой хэргийг Тагнуулын ерөнхий газар шалгадаг болсон нь хэргийг улам хүндрүүлж байна. Ийм нөхцөлд сэтгүүлчид эрх мэдэлтнүүдийн олон нийтийн эрх ашгийг зөрчсөн үйлдлийг эрэн сурвалжлах нь эрсдэлтэй гэж үзэж, зайлсхийх хандлага ажиглагдах болсон. Тодруулбал, эрүүгийн эрх зүйн зохицуулалт нь сэтгүүлчийн хараат бус үйл ажиллагаанд бодитойгоор, сөргөөр нөлөөлж байна.

Дээрх шалтгаануудыг харгалзан үзээд илт худал мэдээлэл тараах тухай Эрүүгийн хуулийн 13.14 дэх заалтыг хүчингүй болговол гүтгэх үйлдлийг Иргэний хуулийн 511.1-ээр зохицуулах боломжтой (талууд хоорондоо тохирч, эвлэрч болдог давуу талтай). Мөн 2015 онд байгуулагдсан Хэвлэл мэдээллийн зөвлөл ч ийм төрлийн гомдлыг ёс зүйн үүднээс шийдвэрлэх боломж өнөөдөр бүрдсэн. Ингэвэл хэвлэл мэдээллийн салбар дахь улс төрчдийн дарамт сүрдүүлэг багасаж, эрэн сурвалжлах сэтгүүл зүй хөгжих хөрс бүрэлдэхэд чухал алхам болно. Гэвч өнөөгийн улс төр, эрх зүйн нөхцөл байдлаас харахад гүтгэх үйлдлийг гэмт хэрэгт тооцон Эрүүгийн хуулиар зохицуулах нь зүйтэй гэсэн үзэл давамгайлж байгаа бөгөөд үүнийг нийгмийн сүлжээн дэх худал,

хуурамч мэдээллийн давлагаа улам өдөөж байна. Улс төрчид, төрийн өндөр албан тушаалтнуудын дунд олон нийт, хэвлэл мэдээллийнхний шүүмжийг тэвчин хүлцэнгүй байх соёл, хандлага ажиглагдахгүй байна.

Ийм нөхцөлд Эрүүгийн хуулийн 14.13 дахь заалтын тодорхойгүй нэр томъёог нэр мөр болгох, санаа зоригийн шаардлагыг нэмэх, улс төрч, төрийн албан хаагчдыг уг хуулийн зүйл, заалтаар гомдол гаргахыг хориглох (эдгээр субъектүүд Иргэний хуулийн

511.1-ээр гомдол гаргах эрх нь нээлттэй) зэргээр нэн яаралтай өөрчлөн найруулах шаардлагатай. Эрүүгийн хууль нь хүчин чадлынхаа хувьд салбарын хуулиасаа давуу хүчин чадалтай. Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуульд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хамгаалсан сайн заалт оруулаад ч хүчин чадлын хувьд Эрүүгийн хууль нь дээгүүр. Тиймд “илт худал мэдээлэл тараах” буюу гүтгэх үйлдэлтэй холбоотой Эрүүгийн хуулийн заалт нь Монголын хэвлэлийн эрх чөлөөний нөхцөл байдлыг дордуулах гол эрх зүйн зохицуулалт болоод буйг анхаарах шаардлагатай байна.

«

**Илт худал мэдээлэл тараах тухай Эрүүгийн хуулийн 13.14 дэх заалтыг хүчингүй болговол гүтгэх үйлдлийг Иргэний хуулийн 511.1-ээр зохицуулах боломжтой (талууд хоорондоо тохирч, эвлэрч болдог давуу талтай). Мөн 2015 онд байгуулагдсан Хэвлэл мэдээллийн зөвлөл ч ийм төрлийн гомдлыг ёс зүйн үүднээс шийдвэрлэх боломж өнөөдөр бүрдсэн. Ингэвэл хэвлэл мэдээллийн салбар дахь улс төрчдийн дарамт сүрдүүлэг багасаж, эрэн сурвалжлах сэтгүүл зүй хөгжих хөрс бүрэлдэхэд чухал алхам болно**

»



### Эшлэл

1. Иргэний оролцоо төсөл. 2020. Монгол Улс дахь хэвлэл мэдээллийн эрх чөлөөний өнөөгийн байдал ба түүнийг олон улсын жишигт нийцүүлэх нь. х104.
2. Иргэний оролцоо төсөл. 2020. Монгол Улс дахь хэвлэл мэдээллийн эрх чөлөөний өнөөгийн байдал ба түүнийг олон улсын жишигт нийцүүлэх нь. х66.
3. Мөнхсайхан О. 2017. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд нийцүүлэн гүтгэлгийг зохицуулах нь. Эрх зүй сэтгүүл. х8.
4. Нарангэрэл С, Эрдэнэбат Г. 2017. Эрүүгийн эрх зүй. х55.
5. Нээлттэй нийгэм форум. 2021. Худал мэдээлэл тараах гэмт хэргийг хянан шийдвэрлэж буй практик. х15.
6. УИХ-ын Тамгын газар. 2017. Цахим болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр бусдын нэр төрийг гутаах, гүтгэх, доромжлох, хуурамч мэдээлэл тараах үйлдэлд хүлээлгэх хариуцлага, бусад орнуудын туршлага. х2.
7. Хууль зүйн яам. 2013. Харьцуулсан эрх зүй. х64.
8. [https://ikon.mn/n/2p2z?fbclid=IwAR0f7W\\_S7o1\\_Oz4mPjid5aKexuBsYU7bAAstCX1isR1p0h59\\_8Xpvi2fjHA1](https://ikon.mn/n/2p2z?fbclid=IwAR0f7W_S7o1_Oz4mPjid5aKexuBsYU7bAAstCX1isR1p0h59_8Xpvi2fjHA1)
9. [https://www.law.cornell.edu/wex/new\\_york\\_times\\_v\\_sullivan\\_\(1964\)](https://www.law.cornell.edu/wex/new_york_times_v_sullivan_(1964))
10. <https://legalinfo.mn/mn/detail/11634>
11. [https://shuukh.mn/single\\_case/50399?date=2020-08-20%20-%202020-08-21&id=1&court\\_cat=2&bb=1](https://shuukh.mn/single_case/50399?date=2020-08-20%20-%202020-08-21&id=1&court_cat=2&bb=1)
5. Нарангэрэл С, Эрдэнэбат Г. 2017. Эрүүгийн эрх зүй. УБ.
6. Нээлттэй нийгэм форум. 2003. Монгол Улс шилжилтийн үед. УБ.
7. Нээлттэй нийгэм форум. 2021. Худал мэдээлэл тараах гэмт хэргийг хянан шийдвэрлэж буй практик. УБ.
8. УИХ-ын Тамгын газар. 2017. Цахим болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр бусдын нэр төрийг гутаах, гүтгэх, доромжлох, хуурамч мэдээлэл тараах үйлдэлд хүлээлгэх хариуцлага, бусад орнуудын туршлага. УБ.
9. Хууль зүйн яам. 2013. Харьцуулсан эрх зүй. УБ.
10. [https://www.gesetze-im-internet.de/englisch\\_stgb/englisch\\_stgb.html](https://www.gesetze-im-internet.de/englisch_stgb/englisch_stgb.html)
11. [https://ikon.mn/n/2p2z?fbclid=IwAR0f7W\\_S7o1\\_Oz4mPjid5aKexuBsYU7bAAstCX1isR1p0h59\\_8Xpvi2fjHA1](https://ikon.mn/n/2p2z?fbclid=IwAR0f7W_S7o1_Oz4mPjid5aKexuBsYU7bAAstCX1isR1p0h59_8Xpvi2fjHA1)
12. [https://www.law.cornell.edu/wex/new\\_york\\_times\\_v\\_sullivan\\_\(1964\)](https://www.law.cornell.edu/wex/new_york_times_v_sullivan_(1964))
13. <https://legalinfo.mn/mn/detail/11634>
14. <https://rsf.org/en/index>
15. [https://shuukh.mn/single\\_case/50399?date=2020-08-20%20-%202020-08-21&id=1&court\\_cat=2&bb=1](https://shuukh.mn/single_case/50399?date=2020-08-20%20-%202020-08-21&id=1&court_cat=2&bb=1)

### Summary

In the field of law and journalism in Mongolia, a common understanding of defamation has been formed, and multilateral position, a database of international regulations is being formed as well. This article aims to present the international experience regulating defamation and to explain the basic conditions of the main legal regulations related to defamation in Mongolia. Also, some cases decided by the court related to defamation were analyzed as examples. The author has explained the reasons for amending or removing Article 13.14 of the Criminal Code, which is the main regulation related to defamation, and proposed to revise the code immediately.

### Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Гантуг Д, Энхтуяа Ч. 1999. Хэвлэл яагаад шарладаг вэ. Эрх чөлөө нь дутагдвал. УБ.
2. Глоб интернэшнл. 2002. Нэр төр, гүтгэлэг. УБ.
3. Иргэний оролцоо төсөл. 2020. Монгол Улс дахь хэвлэл мэдээллийн эрх чөлөөний өнөөгийн байдал ба түүнийг олон улсын жишигт нийцүүлэх нь. УБ.
4. Мөнхсайхан О. 2017. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд нийцүүлэн